



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

┌ Хурлын хороодыг хуралдуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолын хавсралтын 5.1.2 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2025 оны 04 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Хурлын хороодыг хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.

2.Хурлын хороодын хуралдах хуваарь, хэлэлцэх асуудал бүхий удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3.Хурлын хороод хуралдахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба (П.Баянбаатар)-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА  Т.УЛАМБАЯР



Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 03 дугаар сарын 06 -ний өдрийн 21 дугаар захирамжийн хавсралт

УДИРДАМЖ

Хурлын хороодыг хуралдуулах тухай

Нэг.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороод дараах хуваарийн дагуу хуралдах бөгөөд хэлэлцсэн асуудлаар санал, дүгнэлт гаргана.

Хоёр.Хурлын хороод хэлэлцсэн асуудлаар гаргасан санал, дүгнэлтээ 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хурлын Ажлын албанд ирүүлж, 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Хурлын Зөвлөлд танилцуулна.

Гурав.Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар, холбогдох хэлтэс, албад Хурлын хороодыг шаардлагатай мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, ажиллах нөхцөлөөр хангана.

Дөрөв.Хурлын хороод хуралдахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас санхүүжүүлнэ.

Тав.Хороодын ажиллах хуваарь, хэлэлцэх асуудал:

Д/д	Хурлын хороод	Зохион байгуулах үйл ажиллагаа	Хугацаа	Хамтран ажиллах хэлтэс, албад
1	2	3	4	5
1	Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо	“Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028” арга хэмжээний төсөл	2025 оны III/10-ны өдрийн 09 ⁰⁰ цагт, Хурлын танхимд	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
		“Эх оронч цэрэг-2028” арга хэмжээний төсөл		Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб
		“Амар тайван Чингэлтэй-2028” арга хэмжээний төсөл		Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, дүүргийн Цагдаагийн газар
		“Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах		Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын

		үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, иргэдийн оролцоог хангах-2028” арга хэмжээний төсөл		хэлтэс, дүүргийн Онцгой байдлын хэлтэс
2	Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хороо	“Чингэлтэйн боловсрол-2028” арга хэмжээний төсөл	2025 оны III/11-ний өдрийн 09 ⁰⁰ цагт, Хурлын танхимд	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, дүүргийн Боловсролын хэлтэс
		“Эрүүл, спортлог Чингэлтэйчүүд-2028” арга хэмжээний төсөл		Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, дүүргийн Эрүүл мэндийн төв, Биеийн тамир спортын хороо
		“Чингэлтэйн ахмадууд-2028” арга хэмжээний төсөл		Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, дүүргийн Ахмадын хороо
		“Соёлтой иргэн-2028” арга хэмжээний төсөлтэй төсөл		Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, дүүргийн Соёлын төв
		“Хүүхэд залуучуудын хөгжил, хамгаалал-2028” арга хэмжээний төсөл		Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, Хүүхэд хөгжлийн цогцолбор УТҮГ
		“Цахим Чингэлтэй-2028” арга хэмжээний төсөл		Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, дүүргийн Цагдаагийн газар
3	Хүний эрх, ёс зүй, өргөдлийн хороо	“Хүний нөөц, нийгмийн баталгаа-	2025 оны III/12-ны өдрийн 09 ⁰⁰ цагт,	Засаг даргын Тамгын газрын Төрийн

		2028" арга хэмжээний төсөл	Хурлын танхимд	захиргааны удирдлагын хэлтэс
4	Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хороо	"Чингэлтэйд үйлдвэрлэв-2028" арга хэмжээний төсөл	2025 оны III/12-ны өдрийн 13 ⁰⁰ цагт, Хурлын танхимд	Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв
5	Ногоон хөгжил, газрын харилцааны хороо	"Тохилог Чингэлтэй-2028" арга хэмжээний төсөл	2025 оны III/13-ны өдрийн 09 ⁰⁰ цагт, Хурлын танхимд	Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
6	Хот байгуулалт, дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн хороо	"Тохилог Чингэлтэй-2028" арга хэмжээний төсөл	2025 оны III/13-ны өдрийн 13 ⁰⁰ цагт, Хурлын танхимд	Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс